

БАТЛАВ.
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

БАТЛАВ.
ХУНС, ХӨДӨӨ АЖАХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД

Х.БОЛОРЧУЛУУН

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ч.Хүрэлбаатар

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ.
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД

Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.Нямбаатар

Х.НЯМБААТАР

МОНГОЛ УЛС, ДЭЛХИЙН БАНКНЫ ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,
ХӨГЖЛИЙН БАНК БОЛОН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ
ХООРОНДЫН “МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БОЛОН
ЛОГИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хууль тогтоомжийн тесел боловсруулах болсон үндэслэл,
шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэл, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 19, 27-ны өдрийн хуралдааны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр захирамжийг үндэслэн Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах тесел”-ийн Зээлийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан.

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах тесел"-ийн Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэгт заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн еренхий нехцэлийн талаарх олон улсын гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн тесел нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах тесел"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах тесел"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа серег үр дагавар гарагүй бөгөөд тээвэр, логистикийн дэд бүтцийн сүлжээг сайжруулан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний алдагдлыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Дөрөв.Хууль тогтоомжийн тесел Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн тесел нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн тесэлтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.